

Дэлгэрцогт сумын “ХХС”-ийн хяналтын зөвлөлийн ажлын тайлан

ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ-ЫН” дагуу зээлдэгч нарын үйл ажиллагааны хэрэгжилт, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хяналт шалгалт хийлээ.

➤ Хяналт шалгалт явуулсан ажлын бүрэлдэхүүнд

1. Хяналтийн зөвлөлийн дарга П.Мөнхзориг
2. ХЗ-ийн гишүүн Ж.Наранцэцэг
3. ХЗ-ийн нарийн бичиг ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Д.Наранцэцэг

➤ Хяналт шалгалт хийсэн огноо. 2022 оны 11 сарын 22-23 ний өдрүүдэд

2019-2021 онд “Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэрэгжилтийг дараах иргэдийг шалгалаа. Үүнд : иргэн Ч.Доржпүрэв, Өвлийн нарлаг хүлэмж барих 10,000,0 сая төгрөг, Ч.Наранцацралт Салатны үйлдвэрлэлийн чиглэлээр 6.000,0 сая, иргэн Ц.Жууяар “ Цагаан идээ үйлдвэрлэл, борлуулалт” -ын чиглэлээр 20,000,0 сая, В.Амаржаргал “Блокны үйлдвэрлэл байгуулах 10,000,0 сая, иргэн З.Түвшинтөр “Мал нядалгаа газар” 17,000,0 сая, Долгорсүрэн “Бадмаараг” зүү ороосон дайлан, бүс үйлдвэрлэх чиглэлэр 5,000,0 сая, иргэн Б.Баатарсүрэн “Эко төмс “- төмсний тариалалт 5,000,0 сая, О.Цогзолсүрэн “Оргил оёдол 5,000,0 сая”, иргэн А.Мэндсайхан “Цахирын цагаан алт оёдлын чиглэлээр 5000,0 сая, Ширээс хоршоо “Эко арьс шир боловсруулах үйлдвэр” 25.000.0 сая төгрөгийг тус тус зээлийн хэрэгжилтийг шалгахад :

1. “Өвлийн нарлаг хүлэмж барих” “Салатны үйлдвэрлэл” - чиглэлээр зээл авсан иргэн Ч.Доржпүрэв, Ч.Наранцацралт нар гэр бүлийн хүмүүс байдаг. Энэ зун бороо хуртай сайхан жил, ургац сайн боломжийн авсан. Өвлийн хүлэмжийн тариалалт хийгээгүй нүүрс түлээ их ордог, цахилгаан халаалтын зардал их гардаг, хүлэмжийн дулаалга муудсан солих шаардлагатай болсон тухай ярьж байна. Ногоо борлуулалтаас 3,8 сая төгрөг олсон гэвч, хүлэмжийн тоног төхөөрөмж , гадаа талбайн тариалалт, бусад ажлын зардал, 2 уулаа нэмэлт орлогогүй улмаас зээлээ төлж чадахгүй, зээлийн эргэн төлөлтийн хугацаа 2 - уулаа хэтэрсэн, шүүхийн байгууллагад шилжиж, төлбөрөө төлөх чадваргүй зуны хүлэмжүүдээ зах зээлд борлуулахаар цахимаар зар тавиад байгаагаа ярьж учирлаж байсан.

Дүгнэлт: Зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч зээлийн гэрээгээ хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

2. Цагаан идээ үйлдвэрлэл,” -ын чиглэлээр зээл авсан Ц.Жууяар: цагаан идээний боловсруулах тоног төхөөрөмж, үйлдвэрлэл явуулаагүй , УБ хотоос болон орон нутгийн малчдаас цагаан идээг авч өөрийн эзэмшлийн “Нандин дэлгүүрээр цагаан идээний борлуулалт хийж төслөө хэрэгжүүлж дуусгасан байна.

Дүгнэлт: Зээлийг зориулалтын бус ашиглаж, зээлийн гэрээний дагуу эргэн төлөлтийг хугацаанд төлж зээлийг хаасан гэж дүгнэсэн.

3. ““Блокийн үйлдвэрлэл”-ийн чиглэлээр зээл авсан В. Амаржаргал : Төслийг зориулалтын дагуу амжилттай хэрэгжүүлж энэ жил 2000 гаруй блок үйлдвэрлэж 3000,0 сая гаран төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Дүгнэлт: Төслийн амжилтай хэрэгжүүлж байгаа гэж дүгнэсэн.

“Мал нядалгаа газар байгуулах зээл авсан З.Түвшинтөр: мал нядалгааны 14x7, 14x5 хэмжээ бүхий байгууламжтай, энэ жилийн хувьд 1200 толгой мал нядалж, 4200,0 сая төгрөгийн ажил хийгдэж , ажилгүй 4 иргэн түр ажлын байраар ханган ажилласан байна.

Дүгнэлт: Төслийг амжилтай хэрэгжүүлж байгаа гэж дүгнэсэн.

4. “Бадмаараг” зүү ороосон дайлан, бүс үйлдвэрлэх чиглэлээр зээл авсан иргэн Б.Долгорсүрэн: Уг төслийн үйл ажиллагаа тогтмолжсон орон нутгийн иргэдийн захиалгын дагуу хөвөнтэй дан, хурган дээл хийж, мөн өөрийн охин Б.Уранжаргалтай хамтран зүү ороосон дайлан, гутал бүс хийж 2022 онд 3800,0 гаруй төгрөгийн борлуулалт хийж, монгол гутлын хараа, гутлын захиалгатай үйлдвэрлэлээ явуулж байгаа . Мөн зээлээ хугацаанд нь төлөлт хийдэг зээлээ хугацаанаасаа өмнө хаасан .

Дүгнэлт: Төслийг амжилтай хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн.

5. “Эко төмс” төмсний тариалалт хийж орон нутгийн иргэдийг хүнсний ногоогоо хангах чиглэлээр зээл авсан иргэн Б.Баатарсүрэн: Тус иргэн Төв аймгийн Жаргалант суманд жилд 2 га-д түрээсээр 7 дахь жилдээ төмсний тариалалт хийж, өөрийн хашаандаа 15 тн -ний багтаамжтай зорьтой үйл ажиллагаа явуулж, энэ онд 12 тн төмс хураан авч, Төв аймгийн Бор нуур сумаас лууван манжин сонгино, байцааг худалдан авч, ногооны багц болгон 9 сараас эхлэн 3 сар хүртэл борлуулалт хийх нөөцтэй, одоогоор 4800,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Дүгнэлт: төслийг зориулалтын дагуу амжилтай хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн.

6. “Оргил оёдол” -ын чиглэлээр зээл авсан иргэн О. Цогзолсүрэн: Тус иргэн хашаандаа тусгай ажлын байртай, үйл ажиллагаа нь тогтмолжсон,иргэдийн захиалгын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа энэ захиалгатай 22 дээл, 5 хийсэн дээл, 10 монгол цамцхийж 3600,0 гаруй сая төгрөгийн ажил хийсэн.

Дүгнэлт: төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлсэн гэж үзсэн.

7. “Цахирын цагаан алт оёдлын чиглэлээр зээл авсан иргэн А.Мэндсайхан: тус иргэн сумын төвөөс .. км хөдөө мал маллаж амьдардаг, арьс нэхий элдэж үстэй, дан хөвөнтэй дээл, оёх ажлыг ээж ааваасаа уламжилж нийлээн дээрээс хийж өрхийн орлого нэмэгдүүлж, орон нутагтаа хурган дээл хийх, хурганы арьс элдэх, дээлийг гоё сайхан хийдгээрээ алдаршиж захиалга аль ч улиралд их байдаг онцлогтой оёдолчин байна. зээлийн гэрээний дагуу эргэн төлөлтийг хугацаанд хийж, зээлийн мэдээллийн санд хэвийн ангилалтай бүртгэлтэй зээлдэгч байна. 2022 онд 3 хурга дээл, 60 хурганы арьс элдсэн, 16 малгай, 8 монгол цамц, 17 захиалгатай дээл хийсэн байна. тухайн жилдээ 3800-4500,0 төгрөгийн орлоготой ажилсан гэж мэдээ өгсөн.

Дүгнэлт: төслийн амжилтай хэрэгжүүлж байгаа гэж дүгнэсэн.

8. Эко арьс шир боловсруулах үйлдвэр” чиглэлээр зээл авсан: Ширээс хоршоо: Тус хоршоо нь 2004 оноос хойш монгол цагаан эсгий улирлын чанартай үйлдвэрлэл явуулдаг, брэнд бүтээгдэхүүнээр шалгарч байсан, эсгий хийх үеэр 2-4 иргэний түр ажлын байраар хангаж 2015-2022 он хүртэл нийт 2185 м эсгийн хийсэн тайлант онд 380м эсгий үйлдвэрлэсэн. 2020 оноос эхлэн арьс элдэх бага оврын тоног төхөөрөмж авч 2022 онд 1200ш хурганы арьс, 500ш хонь ямааны арьс элдэж гэр бүлийн 2 иргэний түр ажлын байраар хангаж нийт 10.0 гаруй сая төгрөгийн борлуулалттай ажилласан тухай мэдээ өглөө.

Дүгнэлт: Төслийг амжилтай хэрэгжүүлж байгаа гэсэн дүгнэсэн.

Одоогийн байдлаар 2018-2021 онд Төсөл хэрэгжүүлэхээр зээл авсан 9 иргэний явуулж байгаа үйл ажиллагаатай танилцлаа. Төсөл хэрэгжүүлэгчдээс: - Зээлийг зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа - 7 иргэн , зээлийн гэрээний хэрэгжилтийг хангалтгүй буюу хугацаа хэтэрсэн шүүхийн байгууллагад шилжсэн 2 иргэний үйл ажиллагаанд хяналт тавьж “ХХС-ийн шинэчилсэн журмыг танилцуулж мэдээлэл өгч ажиллаа.

ХХС-аас 2018-2021 онд нийт 17 иргэн зээл авсан: Үүнээс төслийг зориулалтын дагуу ашиглаж үйл ажиллагаа явуулж буй 8 иргэн, Төслөө хэрэгжүүлээд дууссан 5 иргэн, төслөө улиралын чанартай, зориулалт бус 2 иргэн, зээлийн хугацаа хэтрэлтэй 2 иргэн байна.

- Цаашид: Барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувийг хадгалах сейфтэй болох
- Зээлийн гэрээнд төслөөр авах тоног төхөөрөмжд хяналт хийх хугацааг тусгах.
- Ажил хүлээлцэхэд зээлдэгч нарын бичиг баримтыг жагсаалтаар хүлээлцэж байх

Иргэдийн үйл ажиллагааны зурган тайлан

Ширээс хоршооны арьс элдсэн байгаа





2. Оёдол А.Мэндсайханы



3. Долгorsүрэн. Уранжаргал



4. Б.Баатарсүрэн



О.Цогзолсүрэн

